

Батлав: БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчин,
Байгалийн Нөөцийн Удирдлагын Газрын Дарга

_____ /...../

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Хархорум Сүлд” ХХК-ийн Гүйцэтгэх Захирал

_____ /М.ТАМИР/

**ТӨВ АЙМАГ БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ИХ БУЛГИЙН ХӨНДИЙН
ДУНД ХЭСГИЙН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021535
Регистрийн дугаар: 3551075

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын

Мэргэжилтэн _____ /...../

Боловсруулсан:

“Хархорум сүлд” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн _____ /Б.Гэрэл/

Улаанбаатар хот, 2026 он

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Их булгийн хөндийн дунд хэсэг” -ийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: Хувийн хөрөнгө оруулалттай “Хархорум сүлд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011806051, Регистрийн дугаар: 3551075, Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар : MV-021535

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 -р хороо, Оргил стадион, 205-503 тоот, Утас: 95007134

Төслийн байршил: “Хархорум сүлд” ХХК -ийн MV-021535 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, 124.42 га талбай бүхий “Их булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш зүгт 123 км, Баян сумаас зүүн тийш 15 км, Багахангай дүүргээс зүүн урагш 22 км -т байрладаг.


Хүснэгт 1. MV-021535 тоот тусгай зөвшөөрлийн цэгийн солбицол

Цэгийн дугаар	Цэгийн солбицол	
	Уртраг	Өргөрөг
1	107° 41' 40.000"	47° 22' 20.000"
2	107° 41' 40.000"	47° 22' 44.000"
3	107° 43' 0.000"	47° 22' 44.000"
4	107° 43' 0.000"	47° 22' 20.000"

Зураг 1. Төслийн талбайн зураг



Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг



1.2 Төслийн нөөц, хүчин чадал, техник тоног төхөөрөмж

Төв аймгийн Баян сумын нутагт орших “Их булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон ордод гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнг Ашигт малтмалын газрын тосны газрын Эрдэс баялгийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн дугаар ХХ-19-09 дүгээр хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлт, Ашигт малтмалын газрын тосны газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Н/124-р дугаар тушаалын дагуу бодитой болон боломжтой (В) нөөцийг шлихээр 13.079 кг-аар, химийн цэврээр 11.378 кг-аар, (С) нөөцийг шлихээр 1.396 кг-аар, химийн цэврээр 1.215 кг-аар, нийт (В+С) нөөцийг 14.47 кг-аар, химийн цэврээр 12.59 кг-аар улсын нэгдсэн нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Уг ордыг ашиглах үйлдвэрлэлийн угаах элсний хэмжээ 45.42 мян.м³, хөрс хуулалт 51.14 мян.м³, алтны хэмжээ шлихээр 14.47 кг, химийн цэврээр 12.59 кг байна. Нийт 1 жилийн хугацаанд олборлоно.

Хүснэгт 2. Техник тоног төхөөрөмж

Ажлын зориулалт	Марк	Тоо, ш
Хөрс хуулалт	Hyundai LC-7 2900	1
Элс олборлолт		
Хөрс болон элс тээвэрлэлт	Howo HW70	1
Туслах ажилд	Liugong ZL50C	1
Овоолго зам талбай,	T-140	1
Нийт		4

1.3 Уурхайн ажиллах горим

Уурхай нь хоногт 10 цагийн үргэлжлэлтэй, 2 ээлжээр ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь улирлын чанартай тул уурхайн техникийн операторууд, жолооч, туслах ажилчид болон ИТА нарыг улирлын чанартай ажиллахаар төсөлд тусгасан. Уурхайн вахтын системээр явагдах ба 1 сар ажиллаад 10 хоног амрахаар төсөлд тусгасан.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	
			Хөрс хуулалт	Элс олборлолт
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10	10
2	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хоног	2	2
3	Ажиллах хоногийн тоо	хоног/жил	90	90

1.4 Их булгийн хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын уулын ажлын хэмжээ, календарь төлөвлөгөө

Захиалагч байгууллагын өгсөн ТЭЗҮ боловсруулах техникийн даалгавар болон ордын уул техникийн нөхцөл, уулын үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл зэргийг харгалзан ордыг ашиглах календарчилсан төлөвлөгөөг дараах байдлаар сонгосон байна.

Хүснэгт 4. Уулын ажлын төлөвлөгөө

Ажлын төрөл	Хэмжих нэгж	Нийт	Ашиглалтын сарууд			
			5-сар	6-сар	7-сар	Нийт
Шимт хөрс хуулалт	м ³	7,898	3,776	3,637	485	7,898
Үндсэн хөрс хуулалт	м ³	43,247	20,743	20,492	2,011	43,247
Элс олборлолт	м ³	45,426	15,000	15,000	15,426	45,426
Дундаж агуулга	мг/м ³	277.21	243.88	299.98	287.47	277.21
Элсэн дэх алтны хэмжээ	кг	12.59	3.66	4.50	4.43	12.59
Металл авалт	%	75.8%	75.8%	75.8%	75.8%	75.8%
Бүтээгдэхүүн гаргалт /химийн цэвэр/	кг	9.54	2.77	3.41	3.36	9.54

1.5 Баяжуулалт

Их Булагийн хөндийн дунд хэсгийн алтны шороон ордыг ашиглах энэхүү төсөлд алт агуулсан элсний найрлага, шинж чанар, технологийн туршилт судалгааны үр дүнд үндэслэн шороон ордын элсийг гравитацийн аргаар баяжуулахаар төлөвлөсөн.

Ордын ашиглалтын нөөцөд тулгуурлан алт агуулсан элсийг 1 жилийн хугацаанд угаан баяжуулахаар тооцоолсон. Ил уурхайгаас олборлосон алттай элсийг гравитацийн аргаар баяжуулан угаах төхөөрөмж бүхий үйлдвэрийг ил уурхайн дэргэд байрлуулах юм.

Алт агуулсан элсийг угаан үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөөг технологийн туршилт, тоо-чанарын тооцоонд үндэслэн тооцсон бөгөөд төслийн хугацаанд 45.42 мян.м³ элсийг угааж 75.78 %-ийн металл авалттай 9.54 кг алт борлуулна.

1.6 Дэд бүтэц

Цахилгаан хангамж

Их булгийн хөндийн дунд хэсгийн алтны шороон ордын цахилгаан хангамжийг дизел генератороор шийднэ. Их булгийн хөндийн дунд хэсгийн алтны шороон ордыг олборлоход цахилгаан хэрэглээнд :

1. Уурхайн тосгон /ахуйн хэрэгцээнд/
2. Ус шахах насос /Д320-90, Д200-90б-2/
3. Уурхайн засварын цех
4. Агуулах
5. Уурхайн цахилгаан гэрэлтүүлэг
6. Скруббер
7. Баяжуулах ширээ, СКО-1

8. Тооцоолоогүй хэрэглэгч

Усан хангамж

Уурхайн унд ахуй болон технологийн усыг гүний худгаас хангахаар ТЭЗҮ –д тусгасан байна.

Хүснэгт 5. Уурхайн нийт усны хэрэгцээний тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 -р жилийн дүн
1	Үйлдвэрийн технологийн усны хэрэгцээ	м ³	54 511.2
2	Унд ахуйн ус хэрэглээ	м ³	445.5
3	Тоосжилт дарах усалгаа	м ³	90
	Нийт	м ³	55 046.7
	Үүнээс : Нэг өдөрт		
	<i>Унд ахуй</i>	м ³ /өдөр	4.95
	<i>Технологийн усны хэрэгцээ</i>	м ³ /өдөр	605.68
	<i>Тоосжилт дарах усалгаа</i>	м ³ /өдөр	2
	Нийт	м³/өдөр	612.63

2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газрын гадарга: Төсөл хэрэгжих нутаг нь Хэнтийн нурууны салбар уулсын баруун өмнөд хэсэгт байрладаг бөгөөд уулс нь мөлгөр бүнхэр оройтой, налуу хааяа эгц хажуутай, далайн түвшинөөс дээш 1550-1583 м дундаж өндөртэй. Физик газар зүйн хувьд Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн тэгш өндөрлөгийн тойрог, Хэрлэн голын өмнөд баруун урд талын нам уулсын тойргуудад тус тус хуваагдан оршино. Төслийн талбай нь намхавтар уулс хооронд томоохон уужим хөндий талд байрлана. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадаргын хувьд баруун талаараа хадан гарштай мөлгөр орой бүхий хэрчигдэл багатай, төв болон зүүн хойд хэсэгт харьцангуй хэрчигдэл ихтэй, уулын ар тал нь эгц налуу гадаргатай.

Баян сумын нутаг дэвсгэрт Баян, Мааньт, Өндөр Хутаг, Жаргалант, Ерөөлтийн хангай, Хөх шувуут зэрэг өндөр уулс бий. Бүс нутаг нь хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд намхавтар уулс хооронд томоохон уужим хөндий тал үргэлжлэх ба энэ нь улмаар өмнө зүгт тал хээрийн бүсэд шилжинэ.

Тус орд нь 53.9-115 м өргөнтэй 0.5 км сунаж тогтсон. 124,42 га талбай бөгөөд L-48-24 хавтгайд байрлана. Газрын гадарга уул хоорондын хөндий бөгөөд байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөөгөөр эвдэрч гуу жалга үүссэн. Хүний үйл ажиллагааны нөлөөлөлд бэлчээрээс өөр хэлбэрээр өртөөгүй, хог хаягдалгүй байна.

Цаг уур: Төв аймгийн уур амьсгалын нөхцөл нь Монгол орны бусад нутаг дэвсгэрийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй, өвөл нь хүйтэн, удаан үргэлжилдэг, зун нь халуун богино, хавар намар нь улирлын шилжилтээс хамааран салхи, шуурга ихтэй байдаг онцлогтой. Баян сумын хувьд уур амьсгалын хуурай мужид хамаардаг, хуурайдуу халуун зунтай, салхи шуурга ихтэй. Жилийн дундаж температур олон жилийн дунджаас илүү нэмэгдэж, хуурай болон хагас хуурай цаг агаар зонхилох болсон байна.

Төслийн талбайн хувьд тус бүс нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай ба жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалын ялгаа тодорхой илэрдэг. Өвлийн улиралд агаарын температур хамгийн бага буюу -22.3, хамгийн их буюу -41.5 хэм хүйтэн байдаг бол зуны улиралд хамгийн их халуун нь +40 хэм хүрдэг.

Хур тунадас ерөнхийдөө бага ордог хэдий ч өвлийн улиралд нийт нутгаар 250-350 мм орчим цасан бүрхүүлтэй болдог. Салхины чиг ихэвчлэн баруун хойноос зүүн урагш чиглэлтэй ба дунджаар 0.3-10м/с хурдтай байна. Өвөл, хаврын улиралд хүчтэй цас болон шороон шуурга шуурна.

Агаарын чанар: Ил уурхайн олборлолт өөрөө агаарын чанарт нөлөөлөх магадлал өндөр байдгаас гадна тухайн орчинд /Баян сумд/ төсөл хөрөгжүүлэгч компаний талбайтай зэргэлдээ орших “Ти Жи Ай” ХХК –ийн алтны шорооны ордны уурхай үйл ажиллагаа явуулж байгаад түр зогссон байдалтай, уурхайлалтын ажил эхлээгүй байгаа тул орчны агаар харьцангуй цэвэр байна.

Гадаргын болон гүний ус: “Хархорум Сүлд” ХХК –ийн “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн талбай нь Хэрлэн голын сав газарт багтаж байна. Голын сүлжээ муу хөгжсөн, нийт талбайгаар хуурай гольдрол, сайрууд хөгжсөн байдаг. Байнгын урсгалтай голууд байхгүй хэдий ч зарим голын сайр, жалгуудад гар худаг байх нь тааралдана. Эрчимшил ихтэй хур борооны үед бага зэргийн гадаргын урсац хуурай сайруудаар үүсэж зарим хотгор хонхор газрыг дүүргэх ерөнхий нөхцөлтэй. Иймд төслийн нутгийн гадаргын урсац уур амьсгалын хүчин зүйлс ялангуяа хур тунадасны хэмжээ, эрчимшил, хөрсний бүтэц, түүний нэвчилтийн багтаамж,

чадавхиас ихээхэн хамаарна. Төслийн талбайн гадна улирлын чанартай булаг бүртгэгдсэн бөгөөд нутгийн иргэд цементээр хамгаалалт хийж хашсан байдалтай байна.

Хөрс: Төв аймгийн Баян сум орчим нутаг нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий тал хээрийн бүсийн уулын хар хүрэн хөрс зонхилсон. Төслийн талбай орчмын газар нь уул хоорондын нарийн хөндийд байрлах ба нам уулс гүвээ, толгодоор хүрээлэгдсэн, толгодын орой нь бөөрөнхий хавтгайдуу оройтой, хөндий жалга ихээр ажиглагдана. Эдгээр хөндий жалганууд нь сулавтар хөгжилтэй цайвар бор хөрс зонхилон тархсан бөгөөд талбайн ихэнх хэсэг нь делювийн нунтаг карбонатлаг дээр үүссэн болно.

“Хархорум Сүлд” ХХК -ийн “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн талбайд уулын хар хүрэн хөрс зонхилон тархсан байна.

Ургамлан нөмрөг: Төв аймгийн Баян сумын нутагт байрлах “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн болон түүний бүс нутагт хийсэн ургамлын аймаг хийгээд ургамалжилтын ажиглалт судалгаанаас үзэхэд хангайн бүсэд хамаарагддаг байна. Төслийн талбай болон түүний орчин тойронд хийсэн судалгааны үр дүнд нийт 1 овог 2 төрөл 5 зүйл ургамалтайг тогтоосон. Ургамалжилтын хувьд тачирхан, маш сийрэг ургамалтай, үет ургамал болон алаг өвс зонхилсон онцлогтой.

Амьтны аймаг: *Alüöüü äéíäëéí öóáüä öýäëýëä äöðüñàíààð ýý ýð÷éí íü ñàðàèð äääääàðäé (myotis mustacinus), äääóóð íääíé (Ochotona daurica), ïííäíë òàðääää (Marmota sibirica), îðîä çóñää (Phodopus sungorus), Äîðíäüí òèø¿¿öýé (Cricetulus pseudogriseus), äääóóðüí ñíîð ìíëí (Myospalax aspalax), öýðäýéçèé íäíðíí (Microtus gregalis), ïííäíë ÷è÷¿¿ë (Meriones unguiculatus), öýðñ (Vulpes corsac), äíð òóóèäé (Lepus tolai), ñíëíäí (Mustela altaica), °íöèé ö¿ðýí (Mustela eversmanii), óðð ñ¿¿èð çóðàì (Citellus undulatus) çýðýä ö°öð°í àüüðää òàððääääñ äääíà Erinaceus dauricus áóóó öíäíð ö°öð°í àüüðäí äääóóðüí çàðää òàððñàí ä¿ñýä äääòäæ ääéíà. Ì°í ïííäíé ääö, öííéí ä¿ðäýé, äíäèéí ä¿ðäýé, ïííäíé ä¿ðäýé, ïííäíé ä¿ðäýé çýðýä àüüðää, ñòì ïííäíé íàðèéí ïííäíé öíäíð äíëíä÷ ääéðäèääää, äàìäè öííðð ïííäíé ýéäýä òàððñàí ääéäää öóðäé äöðüäæýý. Øóáóóäüí ä¿ðäýé ö°öð°í àüüðäüä äíääíé èè¿¿ ääýèää ä°ä°ä ñóóðéí äíëí °íä°äè°æ çóñäää íëíí ç¿èé øóáóóä òàððñàí áóóó ò¿ð çóóð ïðíäíäíä, ääéðäí °íä°äè°ä ä¿ñ íóðäàð ýýö¿¿ çäâíä ïðèèæ ääéíà.*

Нийгэм эдийн засгийн төлөв байдал: Төв аймгийн Баян сум нь анх 1924 онд Түшээт хан аймгийн Богдхаан уулын хошуу Авдарбаян сум, Зогсоол, Жаргалант уулын хошуунд байгуулагдсан. 1956 онд төмөр замын Мааньт өртөөн дээр төвлөрсөн байна. Цант, Өгөөмөр, Цавчир гэсэн 3 багтай, 290,5 мянган га газар нутагтай.

Улаанбаатар хотоос 100 км, Аймгийн төвөөс 85 км зайд байрладаг. Улаанбаатар хотын Багахангай дүүрэг болон Төв аймгийн Сэргэлэн, Баянцагаан, Эрдэнэ, Архуст, Баянжаргалан сумд, урд талаараа Говьсүмбэр аймагтай хиллэдэг.

Баян суманд 2018 оны байдлаар 2,222 хүн амтай бөгөөд нийт 729 өрх айл амьдарч байна. Сумын хүн амын нягтшил 0.8 хүн/км.кв байгаа нь Төв аймгийн бусад сумуудтай харьцуулахад бага нягтшилтай байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх гол нөлөөллүүдийн хураангуй

Төслийн үнэлгээнд байгаль орчин, биологийн хүчин зүйлүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон бүс нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

“Хархорум Сүлд” ХХК -ийн “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн талбай нь Төв аймгийн Баян сумын Цавчир 3-р багийн нутагт, Их булгийн хөндийд Улаанбаатар хотоос зүүн урагш 100 км, Баян сумаас зүүн тийш 15 км, Багахангай дүүргээс зүүн урагш 22 км-т 124.42 га талбайг хамран байрлаж байна. Ерөнхий үнэлгээнд тусгасны дагуу төслийн байршилтай холбоотой асуудлыг тодруулах, тэдгээрийн төсөлтэй холбоотой байх шалтгааныг авч үзэхэд төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй. Төслийн үйл ажиллагааны дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл 124.42 га талбайд хэрэгжих бөгөөд үүнээс ашиглалтын төгсгөлд ойролцоогоор 8.41 га газар нөлөөлөлд өртөхөөр байна.

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл :

- Ил уурхай, овоолго, зам, бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх;
- Уурхай ухаш, овоолго, усан сан, баяжуулах хэсэг зэргийг байгуулахад газрын хэвлийд эвдэх;
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх;
- Ил уурхай, баяжуулах хэсэг, тосгоны объектууд, агуулах зэрэгт өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах зэрэг сөрөг нөлөөтэй.

Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Алтны шороон ордын ойролцоо төвлөрсөн төв суурин газар байхгүй, олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй байгаа цаг үед орчны агаарын чанарт нөлөөлөх хүчин зүйлгүй, агаар орчин харьцангуй цэвэр байна.

Ил уурхайн хөрс хуулалт, тээвэрлэлт, олборлолт болон ажилчдын суурин, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих явцад үүсэх тоосжилт, тээврийн хэрэгслийн хорт утаа, дуу чимээ зэрэг нөлөөлөлөөс агаарын бохирдол буюу тоосжилт үүснэ.

Төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Хархорум Сүлд” ХХК –ийн “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн талбай нь Хэрлэн голын сав газарт багтах бөгөөд Уурхайн технологийн усан хангамжийг гүний худгийн усаар хангана гэж ТЭЗҮ –д тусгасан байна. Технологийн хэрэгцээнд авч ашиглах усны хэмжээгээр газрын гүний усны нөөц, ойр байрлах малчны худгийн усанд хомсдол үүсгэж болзошгүй. Мөн дараах байдлаар гадаргын болон газрын доорх усан орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

- Уурхайн үйл ажиллагааны улмаас байгалийн унаган төрх алдагдан урсац зохицуулах чадавхи буурах, усны ууршилт, нэвчилтээр усны алдагдал бий болох байдлууд үүснэ.
- Хөрсөнд хаясан, асгарсан шингэн /шатах тослох материал/ болон хагуу хаягдлууд хур тунадасны нөлөөгөөр газрын үе давхаргуудад нэвчин бохирдлыг үүсгэнэ.
- Цас борооны усаар хог хаягдал зөөгдөн тархаж хөрс орчныг бохирдуулах
- Ачилт, буулгалт, тээвэрлэлт зэрэг шат дамжлагуудад болон элэгдэж талхлагдсан газраас салхи шуурганы үед үүсэх тоос шороо, утаа тортог эргэн хөрс усан гадаргад бууж тэдгээрийн бүтэц шинж чанарт нөлөөлөх
- Хүчтэй аадар борооны үерийн улмаас бохир усны цооногоос ус алдагдан хөрсний нэвчилтээр дамжин гадаргын усны бохирдол ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх

Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төв аймгийн Баян сум орчим нутаг нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий тал хээрийн бүсийн уулын хар хүрэн хөрс зонхилсон. “Хархорум Сүлд” ХХК -ийн “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн талбайд уулын хар хүрэн хөрс зонхилон тархсан байна.

- ТЭЗҮ–д дурдсанаар төсөл хэрэгжих хугацаанд нийт 7.9 мян.м³ үржил шимт хөрс, 43.2 мян.м³ хөрс хуулж, 8.41 га талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлд оруулах;
- Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах, хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсэх
- Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх
- Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон усаар угаагдаж элэгдэх
- Хөрс эвдэрч физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах

Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төв аймгийн Баян сумын нутагт байрлах “Их булгийн хөндийн дунд хэсэг” алтны шороон орд төслийн болон түүний бүс нутагт хийсэн ургамлын аймаг хийгээд ургамалжилтын ажиглалт судалгаанаас үзэхэд хангайн бүсэд хамаарагддаг байна. Төслийн талбай болон түүний орчин тойронд хийсэн судалгааны үр дүнд нийт 1 овог 2 төрөл 5 зүйл ургамалтайг тогтоосон.

- Тоосжилт үүссэнээс ургамал ба ургамлын бүрхэвч дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.
- Уурхайлалт, барилга байгууламж, дэд бүтцийн үйл ажиллагаагаар хэсэг газрын ургамал бүрмөсөн устах юм. Ургамал талхлагдахад салаа зам, машин техник замбараагүй зорчих нь сөргөөр нөлөөлнө.
- Биологийн төрөл зүйл багасах
- Уурхайн үйл ажиллагаа явагдахад зам талбайд хөрс ургамлын хамтаар амьтны аймаг ялангуяа шавж хорхой үе нугаламгүй амьтад, шавж идэштэн, хэвлээр явагч хийгээд бичил амьтад устаж үгүй болно. Амьтан устах, дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг өөрчлөлт нөлөөллөөс үүдэн амьтны аймагт дам нөлөө аль нэг хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэргэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж зурвас нутгийн орчноос холдоно.

Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд хүн машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс, уурхайн олборлолтын үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дээрх төрлийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээшэн нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах бөгөөд энэ явцдаа олноор тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад махчин амьтдын идэш болох зэрэг зүй бус хорогдолд өртөж болзошгүй юм.

Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн орчинд оршин суугчид үгүй учир нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөхгүй, нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.

Төслийг хэрэгжүүлэх явцад 33 хүнийг ажлын байраар хангана. Төсөл хэрэгжихэд нийт 311.2 сая төгрөг шаардлагатай байна. Ашиглалтын 1 жилд нийт 9.52 кг химийн цэвэр алт борлуулж 1 376.5 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллах бөгөөд нийт үйл ажиллагааны зардал нь 798.1 сая төгрөг, татварын дараах цэвэр ашиг нь 520.5 сая төгрөг байхаар тооцоо гарсан.

Төсөл хэрэгжсэнээр нийт 33 хүний ажлын байр шинээр бий болж Улсын болон орон нутгийн төсөвт нийт 199.9 сая төгрөгийн татвар төлбөр, хураамжийг төвлөрүүлнэ төвлөрүүлнэ.

Ил уурхайн олборлолтын ажил нь тоос болон дуу чимээний нөлөөг ойролцоо нутаглах иргэдэд үзүүлэх болно. Ил уурхай, ажилчдын суурингийн ойр зорчих машин тэрэгний тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

Төслөөс түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй бөгөөд илэрсэн тохиолдолд тэр даруйд нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагад мэдээллэх үүрэгтэй. Тус төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй.

Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Их булгийн алтны шороон ордыг олборлох төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнгүүдийг нэгтгэх нь байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсүүд, түүн дэх нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэгддэг. Их булгийн дунд хэсгийн алтны шороон ордыг олборлох төслөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үр дүнгүүдийг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1. Байгаль орчин					
Газрын гадарга, хэвлий	0	-2	-3	0	0
Газрын гадарга ба газар доорх ус	1	-1	-1	0	0

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
Агаарын чанар	0	-4	-2	0	0
Хөрс	0	-1	-3	0	0
Ургамал	0	-1	-2	0	0
Амьтан	0	-1	-3	0	0
Нийт нөлөөллийн тоо	1	10	14	0	0
Эзлэх хувь	4%	40 %	56 %		0
2. Нийгэм эдийн засгийн орчин					
Нутгийн оршин суугчид	0	-1	+3	0	0
Түүх соёлын дурсгал	0	0	0	0	0
Нийт нөлөөллийн тоо	0	1	3	0	0
Эзлэх хувь		25 %	75 %	0	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт 40 хувь нь бага, 56 % нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 25 хувь нь бага /сөрөг/, 75 хувь нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна. Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл хэрэгжихэд байгаль орчинд болон нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.				

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2026 онд төслөө эхлүүлж хэрэгжүүлэхтэй холбоотой БОННУ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг уурхайн олборлолтын үед байгаль орчинд учирч болох нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдлийг бууруулах үндсэн үйл ажиллагааг явуулах болно.

Нөхөн сэргээлт: Энэ жил техникийн нөхөн сэргээлтийг 3.1 га-д буюу нийт 7.9 мян.м3 шимт хөрсийг хуулах, ухааж ачих тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэхээр байна.

Хөрс хуулалтын ажлын явцад гарах үржил шимт хөрсийг уурхайг хааж, биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор гадаад овоолго хийж хадгална. Ашиглагдсан орон зайд хөрс болон хоосон чулуулгаар дотоод овоолгоор дүүргэлт хийнэ. Дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийсэн талбайн гадаргууд тэгшилгээ хийсний дараа, шимт хөрсний овоолгоос үржил шимт хөрсийг нөхөн сэргээлтийн ажил хийгдэж буй талбай луу түрж 20 см үеэр хучин хэлбэршүүлж засна. Нөхөн сэргээгдэж буй газар, түүний хүрээлэн буй орчин нь олборлолтын дараа байгалийн тэнцвэрт байдлаа хадгалсан, унаган төрхөмдөө ойртсон хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байхаар хийгдэнэ. Төлөвлөгөөний биелэлтийг улирал бүрийн эцэст нарийвчлан хэлэлцэж гүйцэтгэл тайланг сум, аймгийн холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч, мэргэжлийн хяналтын байгууллагуудад танилцуулж байна.

Монгол улсын эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандарт :

- Байгаль орчин, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томьёо, тодорхойлолт MNS 5914 :2008
- Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915 :2008
- Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 :2008
- Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917 :2008
- Байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 :2008

Уурхай дотоод овоолгоор явагдах бөгөөд уурхайн техникийн нөхөн сэргээлт давхар явагдахаар тооцооллоо.

Дүйцүүлэн хамгаалал: 2026 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Төв аймаг Баян сумын Байгаль орчны газартай хамтран дүйцүүлэн хамгаалах боломжит газрыг сонгон тохирсон газарт биологийн олон янз байдлын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, биологийн олон янз байдлыг хамгаалах ажлыг хийнэ.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө: Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө: Техник технологи галын аюулгүй байдлын бүрэн хангуулах, болзошгүй осол эрсдлийн үед ажилчдыг болон шаардлагатай техник тоног төхөөрөмжийг бэлэн байхад бэлтгэх зэрэг ажлыг энэ онд хийж гүйцэтгэхээр төлөвлөлөө.

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө: Ахуйн хуурай хог хаягдлыг цэвэрлэн ангилан ялгах хогийн цэгт битүүмжлэл сайтай хурааж, 1 машин буюу 30 тн-ы хэмжээнд хүрэхээр орон нутгийн зөвшөөрөгдсөн нэгдсэн хогийн цэгт хаяна. Баян сумын хог хаягдал

цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, эсвэл орон нутгаас зөвшөөрсөн хогийн цэгт өөрсдийн техникээр хүргэж зайлуулах ажлыг төлөвлөж байна. Уурхай эхэлж байгаатай холбоотой Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг энэхүү төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийх бөгөөд агаарын бохирдол тоосны шинжилгээг жилд 2 удаа төсөл хэрэгжих талбайн зонхилох салхины дээд доод талд хяналтын 2 цэг сонгон хийнэ. Шинжилгээний зардал 1 удаад 60.0 мян.төгрөг байна. Хөрсөн бүрхэвчинд хөрсний агрохими болон хүнд металлын агууламжийг хагас жил тутам шалгуулна. Нийт шинжилгээний зардал нэг удаад 636.0 мян.төгрөг байна.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох,	Уурхайн талбайн хэмжээгээр	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
	Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч байх;	Үйлдвэрийн байранд	1 200.0	1 200.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Уурхайн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
Агаарын бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нуггийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, замыг хусаж байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр ажилчдыг хангах,	Ажиллах хугацаанд бүх хүнд	ҮАЗ-д	ҮАЗ-д	Жил бүр	
НИЙТ ДҮН				1 200.0		
УСАН ОРЧИН						
Ус ашиглах	Гүний худагт тоолууржуулах, хамгаалалтын бүс тогтоож ажиллах, хяналтын цооног суурилуулах	Төслийн хүрээнд	1 500.0	1 500.0	2026 онд	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Ахуйн болон ногоон байгууламж, тоосжилт дарах ус хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, усыг дахин хэрэглэх, хэмнэлттэй зарцуулах техник технологи судлах, ашиглах	Үйл ажиллагааны турш	-	-	Улирал тутамд	ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982 БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Ус ашиглалтын зөвшөөрөл авах, гэрээг холбогдох орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Уурхай ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	-	Төслийн эхэнд	
	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авах, төлөвлөлт боловсруулах	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Бороо цас үерийн ус цуглуулах сан байгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх, үерээс хамгаалах далан байгуулах	Боломжит газрыг сонгох ажиллах хугацаанд	ҮАЗардалд	-	2026 он	
Нийт дүн				1 500.0		
ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 2 м -ээс өндөргүй овоолон хадгалах.	Үйл ажиллагааны турш	-	ҮАЗардалд	Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээMNS 5915:2008
	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох.	Үйл ажиллагааны турш	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
Тээвэрлэлтийн улмаас	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Төслийн талбайд	-	-	Тухай бүрд	

Төв аймаг Баян сумын нутагт орших “Их Булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
хөрсний эвдрэл үүсэх	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Төслийн талбайд	200.0	200.0	Жил бүр	
Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
	ШТМ, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	Агуулахуудын орчимд	-	-	2026 онд	
	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд	-	-	Тухай бүрд	
Нийт зардал				200.0		
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал				2 900.0		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт						
Шимт хөрсийг хуулах, хөрс хамгаалах зардал	мян.м ³	7.9	200	1 500.0	2026 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Техникийн нөхөн сэргээлтийн нийт зардлын дүн				1 500.0		
Биологийн нөхөн сэргээлт						
Бүрхэвч ургамал тарих, ургамлын үр суулгах	га	3	400.0	1 200.0	2026 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд

Төв аймаг Баян сумын нутагт орших “Их Булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Биологийн нөхөн сэргээлтийн ажлын нийт зардлын дүн	1 200.0		
Нийт дүн	2 700.0		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж тохирсон газарт ойжуулах, хөрс хамгаалах, цөлжилтийг бууруулах арга хэмжээ авах	Төв аймаг Баян сум	-	5 000.0	2026 онд	
	Амьтдын тоо толгой буурах, дайжих амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомсдохоос хамгаалах	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	ҮА-ны зардал	ҮА-ны зардал	Төслийн бүх үе шатанд	Амьтны тухай хууль
		Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-	-	Төслийн бүх үе шатанд	Усны тухай хууль
		Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	ҮА-ны зардал	ҮА-ны зардал	Төслийн бүх үе шатанд	-
Нийт дүн					5 000.0		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Ил уурхайд, усан сан, барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	ҮАЗардалд	-	Өдөр бүр, тогтмол /уурхайн байгаль орчны мэргэжилтэн хариуцна/	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд Уурхайн бүх ажилчдад	200.0	200.0	Жилд 2 удаа	Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Төслийн хүрээнд	Галын хор 10 ш x 60.0 = 600.0	600.0	2026 онд	
Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох	Суурингийн Барилгын ажлын үед	ҮАЗардалд	-	Төслийн хүрээнд	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	-	-	Төслийн хүрээнд	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	Жил бүр	

Төв аймаг Баян сумын нутагт орших “Их Булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	ҮАЗардалд	-	Жил бүр	
Нийт дүн			800.0			

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Их булгийн хөндийн дунд хэсэг алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас гарч буй хатуу, шингэн, төлөв байдлын бүх төрлийн хог хаягдлуудын зохицуулалтад, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартууд, байгууллагын дотоод журмыг мөрдөн ажиллана.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	-	2026 онд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	800.0	800.0	2026 онд	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ	-	2026 онд	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Хэрэглээний хэмжээгээр	-	Жил бүр	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	-	-	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924 : 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх.Техникийн шаардлага” стандартын дагуу барьж ашиглах	Ажилчдын сууринд	ҮАЗардалд	-	2026 онд	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,

Төв аймаг Баян сумын нутагт орших “Их Булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАЗардалд тусгах	2026 онд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
НИЙТ ДҮН				800.0		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд Х _{доол} = 107° 42' 59.063" Ү _{доод} = 47° 22' 33.593" Х _{дээд} = 107° 42' 35.193" Ү _{дээд} = 47° 22' 44.526"	Жилд 1 удаа	Шинжилгээний зардал: 60.0 х жилд 1 удаа 60.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах				
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
Хөрсний бохирдол						

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 3 цэг сонгох ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэг, уурхайн талбайд X ₁ = 107° 42' 19.816" Y ₁ = 47° 22' 41.543" X ₂ = 107° 42' 53.132" Y ₂ = 47° 22' 42.345" X ₃ = 107° 42' 53.749" Y ₃ = 47° 22' 32.061"	Хагас жил тутамд	3 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х /20.0/ НИЙТ 240.0 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж-20.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	Дээрх 3 цэгт	Хагас жилд тутам	3 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 33,0 Нийт 396.0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 33.0 төг/	
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ, эрүүл ахуйн шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйг хангаж буй гүний худаг X ₁ = 107° 42' 46.172" Y ₁ = 47° 22' 28.398"	Жилд 1 удаа	Нийт 140.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Ургамлын аймаг						

Төв аймаг Баян сумын нутагт орших “Их Булгийн хөндийн дунд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
2026 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
3.1	Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт Х _{бич1} = 107° 42' 58.735" Ү _{бич1} = 47° 22' 29.728" Х _{бич2} = 107° 42' 29.405" Ү _{бич2} = 47° 22' 40.183	Жилд 1 удаа	500.0	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					1 336.0	

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаал
1	Сургалт	0.6	0.2	0.2	0.2	ХАБЭА, БО ажилтан
Нийт дүн /мян.төг/			600.0			

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Хархорум сүлд” ХХК жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах,	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг	-
БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн	Тайланг хүлээн авсан актыг	12-р сар	-	-